



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2024/153/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Баянхонгор хот 2024 оны 02 дүгээр сарын 23</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: М.Алтантуяа Утас: 70442424 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn</p> <p>Аудитор: Н.Бунчинсүрэн Утас: 99049866 Цахим хаяг: bunchinsurenn@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	15
4.1 Ерөнхий зүйл.....	15
4.2 Материаллаг байдал .....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	17
4.5.1 Завсрын аудитын талаар .....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	20

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



БӨМБӨГӨР СУМЫН ЗДТГ-ЫН  
ДАРГА Ц.МӨНХЖАРГАЛ ТАНАА

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2024.02.23 № 2/62

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын ЗДТГ-ын оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын ЗДТГ-ын оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

- Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн дүн нь гүйцэтгэлийн үе шатанд тооцсон материаллаг байдлын дүнгээс хэтэрсэн;
- Байгал хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас ан, агнуурын бүс нутгийн 2 газарт булаг, шандыг хашиж хамгаалах, сэргээн засварлах 30,000.0 мянган төгрөгийн ажлыг гүйцэтгүүлэхдээ худалдан авах ажиллагаа зохон байгуулаагүй.
- Төрийн хэмнэлтийн хуулийг мөрдөн ажиллаагүй
- Автотээврийн хэрэгслийн ашиглалт, сэлбэг эд ангийг солихдоо байгууллагын өмч хамгаалах зөвлөл нь шийдвэр гаргаагүй;
- Шилэн дансны мэдээллийг хугацаанд үнэн зөв мэдээлээгүй байна.

Энэ нь Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т "Засгийн газар нь барааны, ажлын, үйлчилгээний гэсэн ангилал тус бүрээр дараахь босго үнийг тогтооно" 8.1.1-т "Харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар", Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолын хавсралтад заасан босго үнийг баримтлаагүй, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-т "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.4-т "Үнэн зөв байх", Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 04 сарын 03-ны өдрийн 86 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам"-ын 3.13-т "Өмч хамгаалах зөвлөл нь хуулийн этгээдийн тээврийн хэрэгсэл, тоног

5020236

d/бичиг хэрэг/2024-а4-албан тоот.docx

төхөөрөмжийн ашиглалт, сэлбэг эд ангийг солих, барлга байгууламжийн их засвар хийх тохиолдолд батлагдсан норм стандартыг мөрдүүлэх, барилгын болон техникийн хувийн хэрэгт нь баяжилт хийлгэх зэргээр хяналт тавьж ажиллана", гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

### **Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй, 2023 онд 70106 (Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага) хөтөлбөрийн 5 арга хэмжээний зардалд 750,367.4 мянган төгрөгийн санхүүжилт батлагдаж, гүйцэтгэлээр 717,036.2 мянган төгрөгийг зарцуулж 32,331.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

### **Аудитын гол асуудал**

Аудитын дүгнэлтийн үндэслэл болгосон зөрчил дутагдал нь төлөвлөлтийн шатанд бидний урьдчилан тогтоосон материаллаг байдлаас хэтэрсэн бөгөөд аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүссэн тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 9 зорилтын хүрээнд 39 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 87.5 хувиар үнэлсэн байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

Б.МӨНХБАТ

**Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**  
**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>60,382,326.92</b>	<b>167,740,569.37</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>14,793.92</b>	<b>57,732,001.37</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	14,793.92	0
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>0</b>	<b>57,732,001.37</b>
33510	Байгууллагаас авах авлага	0	57,732,001.37
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>60,367,533.00</b>	<b>110,008,568.00</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>6,852,333.00</b>	<b>6,852,333.00</b>
35110	Тусгай зориулалттай материал	6,852,333.00	6,852,333.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	14,930,400.00	12,926,400.00
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>38,584,800.00</b>	<b>54,201,000.00</b>
35410	Бичиг хэргийн материал	200,000.00	200,000.00
35420	Аж ахуйн материал	24,679,600.00	32,809,600.00
35430	Сэлбэг хэрэгсэл	13,705,200.00	21,191,400.00
35600	Мал амьтад	0	36,028,835.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,209,114,585.33</b>	<b>1,221,081,641.18</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,209,114,585.33</b>	<b>1,221,081,641.18</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,188,228,481.09</b>	<b>1,201,702,099.41</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,279,759,337.51	1,284,759,337.51
39202	Хуримтлагдсан элэгдэл	-370,736,900.14	-432,302,272.53
39203	Авто-тээврийн хэрэгсэл	202,586,390.30	215,232,015.30
39204	Хуримтлагдсан элэгдэл	-192,831,390.30	-198,459,723.64
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	378,976,425.98	408,376,555.98
39206	Хуримтлагдсан элэгдэл	-260,062,126.36	-214,768,075.48
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	69,646,955.00	70,446,955.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-47,369,490.43	-51,164,420.92
39214	Бусад үндсэн хөрөнгө	146,424,914.19	146,424,914.19
39215	Хуримтлагдсан элэгдэл	-20,295,434.66	-28,972,986.00
39217	Ном	2,129,800.00	2,129,800.00
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>20,886,104.24</b>	<b>19,379,541.77</b>
39301	Програм хангамж	750,000.00	750,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-550,000.00	-662,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	29,501,000.00	29,501,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-8,814,895.76	-10,208,958.23
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,269,496,912.25</b>	<b>1,388,822,210.55</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>557,382.02</b>	<b>6,542.44</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>557,382.02</b>	<b>6,542.44</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>557,382.02</b>	<b>6,542.44</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	485,270.02	0
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	<b>72,112.00</b>	<b>6,542.44</b>
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	72,112.00	6,542.44
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,268,939,530.23</b>	<b>1,388,815,668.11</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,268,939,530.23</b>	<b>1,388,815,668.11</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	525,196,220.52	525,196,220.52
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	525,196,220.52	525,196,220.52
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>169,472,769.52</b>	<b>317,948,907.40</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	169,473,769.52	255,672,769.52
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	62,276,137.88
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	574,270,540.19	545,670,540.19
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,269,496,912.25</b>	<b>1,388,822,210.55</b>

**Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**  
**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан** **/төгрөгөөр/**

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>681,672,926.54</b>	<b>974,103,613.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>185,850,635.00</b>	<b>117,368,460.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>185,850,635.00</b>	<b>117,368,460.00</b>
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	171,850,635.00	52,433,225.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	14,000,000.00	64,935,235.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>495,822,291.54</b>	<b>856,735,153.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>21,938,691.54</b>	<b>107,367,753.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,938,691.54	107,367,753.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>473,883,600.00</b>	<b>749,367,400.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	473,883,600.00	749,367,400.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>545,029,149.31</b>	<b>911,827,475.12</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>545,029,149.31</b>	<b>911,827,475.12</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>503,876,110.73</b>	<b>775,082,992.08</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>240,828,984.00</b>	<b>383,444,765.24</b>
210101	Үндсэн цалин	240,828,984.00	279,776,759.34
210102	Нэмэгдэл	0	86,373,494.26
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0	7,409,000.00
210104	Урамшуулал	0	9,885,511.64
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>30,425,248.95</b>	<b>48,077,400.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	20,633,237.98	32,733,009.23
210202	Тэтгэмжийн даатгал	2,547,897.39	3,850,942.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,931,631.05	3,067,553.82
210204	Ажилгүйдлийн даатгал	482,412.24	757,010.21
210205	Эрүүл мэндийн даатгал	4,830,070.29	7,668,884.55
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>28,411,721.89</b>	<b>43,050,807.69</b>
210301	Гэрэл, цахилгаан	8,855,321.89	10,518,141.69
210302	Түлш, халаалт	19,556,400.00	32,504,666.00
210303	Цэвэр, бохир ус	0	28,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>60,087,810.00</b>	<b>73,524,869.00</b>
210401	Бичиг хэрэг	6,267,600.00	13,341,050.00
210402	Тээвэр, шатахуун	45,046,710.00	40,743,116.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	622,500.00	566,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,500,000.00	15,734,703.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	651,000.00	3,140,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>5,297,000.00</b>	<b>3,500,000.00</b>
210604	Урсгал засвар	5,297,000.00	3,500,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,916,000.00</b>	<b>5,704,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,916,000.00	5,704,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>10,703,288.23</b>	<b>19,822,121.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,833,468.23	12,642,420.00
210803	Даатгалын үйлчилгээ	0	799,525.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	18,000.00	2,196,352.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	40,000.00	136,250.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,811,820.00	3,564,000.00
210807	Газрын төлбөр	0	483,574.00

**Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>125,206,057.66</b>	<b>197,959,029.15</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,000,100.00	99,785,080.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0	4,695,250.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	95,205,957.66	93,478,699.15
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>41,153,038.58</b>	<b>136,744,483.04</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>26,693,766.00</b>	<b>4,950,000.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0	445,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	25,393,766.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,300,000.00	4,505,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>14,459,272.58</b>	<b>131,794,483.04</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,384,704.16	32,331,236.04
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	7,074,568.42	99,463,247.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>136,643,777.23</b>	<b>62,276,137.88</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>4,997,000.00</b>	<b>0</b>
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	4,997,000.00	0
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>131,646,777.23</b>	<b>62,276,137.88</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>495,822,291.54</b>	<b>856,735,153.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>495,822,291.54</b>	<b>856,735,153.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>21,938,691.54</b>	<b>107,367,753.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,938,691.54	107,367,753.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>473,883,600.00</b>	<b>749,367,400.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	473,883,600.00	749,367,400.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>451,776,891.54</b>	<b>803,722,623.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>451,776,891.54</b>	<b>803,722,623.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>410,623,852.96</b>	<b>666,978,139.96</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>238,282,632.84</b>	<b>384,280,612.27</b>
210101	Үндсэн цалин	175,914,233.84	237,243,558.50
210102	Нэмэгдэл	47,151,690.00	116,895,292.27
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0	7,409,000.00
210104	Урамшуулал	0	9,868,842.50
210105	Гэрээт ажлын хөлс	15,216,709.00	12,863,919.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>32,487,400.00</b>	<b>47,909,600.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	22,231,300.00	31,833,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,051,300.00	3,536,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,564,000.00	3,697,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	512,800.00	803,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,128,000.00	8,038,400.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>27,471,687.00</b>	<b>43,053,807.69</b>
210301	Гэрэл, цахилгаан	7,915,287.00	10,518,141.69
210302	Түлш, халаалт	19,556,400.00	32,507,666.00
210303	Цэвэр, бохир ус	0	28,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>48,948,800.00</b>	<b>49,858,313.00</b>
210401	Бичиг хэрэг	5,610,000.00	5,860,550.00

**Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210402	Тээвэр, шатахуун	29,759,700.00	21,746,660.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,029,100.00	1,278,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	11,950,000.00	17,833,103.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	600,000.00	3,140,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>9,497,000.00</b>	<b>4,100,000.00</b>
210604	Урсгал засвар	9,497,000.00	4,100,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,916,000.00</b>	<b>5,676,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,916,000.00	5,676,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>13,771,723.12</b>	<b>28,398,327.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,150,123.12	21,221,626.00
210803	Даатгалын үйлчилгээ	0	799,525.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	18,000.00	2,193,352.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	40,000.00	136,250.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,563,600.00	3,564,000.00
210807	Газрын төлбөр	0	483,574.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>37,248,610.00</b>	<b>103,701,480.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	37,248,610.00	98,729,730.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0	4,971,750.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>41,153,038.58</b>	<b>136,744,483.04</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>26,693,766.00</b>	<b>4,950,000.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0	360,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	25,393,766.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,300,000.00	4,590,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>14,459,272.58</b>	<b>131,794,483.04</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,384,704.16	32,331,236.04
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	7,074,568.42	99,463,247.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>44,045,400.00</b>	<b>53,012,530.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>44,045,400.00</b>	<b>53,012,530.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>44,045,400.00</b>	<b>53,012,530.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>44,045,400.00</b>	<b>53,012,530.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	44,045,400.00	53,012,530.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-44,045,400.00</b>	<b>-53,012,530.00</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	525,196,220.52	574,270,540.19	37,825,992.29	1,137,292,753.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	525,196,220.52	574,270,540.19	37,825,992.29	1,137,292,753.00

**Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

9	Тайлант үеийн үр дүн	0	0	131,646,777.23	131,646,777.23
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	525,196,220.52	574,270,540.19	169,472,769.52	1,268,939,530.23
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	525,196,220.52	574,270,540.19	169,472,769.52	1,268,939,530.23
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	28,600,000.00	28,600,000.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	525,196,220.52	574,270,540.19	198,072,769.52	1,297,539,530.23
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	-28,600,000.00	0	-28,600,000.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	57,600,000.00	57,600,000.00
19	Тайлант үеийн үр дүн	0	0	62,276,137.88	62,276,137.88
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	525,196,220.52	545,670,540.19	317,948,907.40	1,388,815,668.11

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	хувь
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>750,367,400.00</b>	<b>717,036,163.96</b>	<b>33,331,236.04</b>	<b>95.6</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>750,367,400.00</b>	<b>717,036,163.96</b>	<b>33,331,236.04</b>	<b>95.6</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>744,717,400.00</b>	<b>712,086,163.96</b>	<b>32,631,236.04</b>	<b>95.6</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>384,344,100.00</b>	<b>384,280,612.27</b>	<b>63,487.73</b>	<b>100.0</b>
210101	Үндсэн цалин	240,679,500.00	237,243,558.50	3,435,941.50	98.6
210102	Нэмэгдэл	130,177,500.00	116,895,292.27	13,282,207.73	89.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0	7,409,000.00	-7,409,000.00	0.0
210104	Урамшуулал	0	9,868,842.50	-9,868,842.50	0.0
210105	Гэрээт ажлын хөлс	13,487,100.00	12,863,919.00	623,181.00	95.4
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>47,909,600.00</b>	<b>47,909,600.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
210201	Тэтгэврийн даатгал	31,833,500.00	31,833,500.00	0.00	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	3,536,800.00	3,536,800.00	0.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,697,100.00	3,697,100.00	0.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	803,800.00	803,800.00	0.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	8,038,400.00	8,038,400.00	0.00	100.0
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>45,700,800.00</b>	<b>43,053,807.69</b>	<b>2,646,992.31</b>	<b>94.2</b>
210301	Гэрэл, цахилгаан	11,287,000.00	10,518,141.69	768,858.31	93.2
210302	Түлш, халаалт	33,413,800.00	32,507,666.00	906,134.00	97.3
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	28,000.00	972,000.00	2.8
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>50,345,200.00</b>	<b>50,218,313.00</b>	<b>126,887.00</b>	<b>99.7</b>
210401	Бичиг хэрэг	5,881,400.00	5,860,550.00	20,850.00	99.6
210402	Тээвэр, шатахуун	21,766,600.00	21,746,660.00	19,940.00	99.9

**Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,700,200.00	1,638,000.00	62,200.00	96.3
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	17,855,000.00	17,833,103.00	21,897.00	99.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,142,000.00	3,140,000.00	2,000.00	99.9
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>37,600,000.00</b>	<b>37,570,000.00</b>	<b>30,000.00</b>	<b>99.9</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	33,500,000.00	33,470,000.00	30,000.00	99.9
210604	Урсгал засвар	4,100,000.00	4,100,000.00	0.00	100.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>5,695,700.00</b>	<b>5,676,000.00</b>	<b>19,700.00</b>	<b>99.7</b>
210702	Дотоод албан томилолт	5,695,700.00	5,676,000.00	19,700.00	99.7
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>22,122,000.00</b>	<b>20,696,551.00</b>	<b>1,425,449.00</b>	<b>93.6</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,000,000.00	13,519,850.00	480,150.00	96.6
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	0	500,000.00	0.0
210803	Даатгалын үйлчилгээ	800,000.00	799,525.00	475.00	99.9
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,218,000.00	2,193,352.00	24,648.00	98.9
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	240,000.00	136,250.00	103,750.00	56.8
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,564,000.00	3,564,000.00	0.00	100.0
210807	Газрын төлбөр	500,000.00	483,574.00	16,426.00	96.7
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	300,000.00	0	300,000.00	0.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>151,000,000.00</b>	<b>122,681,280.00</b>	<b>28,318,720.00</b>	<b>81.2</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	146,000,000.00	117,709,530.00	28,290,470.00	80.6
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,000,000.00	4,971,750.00	28,250.00	99.4
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>5,650,000.00</b>	<b>4,950,000.00</b>	<b>700,000.00</b>	<b>87.6</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>5,650,000.00</b>	<b>4,950,000.00</b>	<b>700,000.00</b>	<b>87.6</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,650,000.00	4,950,000.00	700,000.00	87.6
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>750,367,400.00</b>	<b>749,367,400.00</b>	<b>1,000,000.00</b>	<b>99.9</b>
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>749,367,400.00</b>	<b>749,367,400.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
320001	Орон нутгийн төсвөөс	749,367,400.00	749,367,400.00	0.00	100.0
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>1,000,000.00</b>	<b>0</b>	<b>1,000,000.00</b>	<b>0.0</b>
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	0	1,000,000.00	0.0
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>51</b>	<b>51</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
610001	Төсвийн байгууллага	1	1	0.00	100.0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>25</b>	<b>25</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
620001	Удирдах ажилтан	7	7	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	11	11	0.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	3	3	0.00	100.0
620004	Гэрээт ажилтан	4	4	0.00	100.0
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>25</b>	<b>25</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>

Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан					
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	8	8	0.00	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	7	7	0.00	100.0
650010	Гэрээт ажилтан	4	4	0.00	100.0
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	6	6	0.00	100.0

## 2.5 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>107,367,753.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>107,367,753.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	7,904,506.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	7,904,506.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,904,506.00
2133	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>99,463,247.00</b>
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	99,463,247.00
II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	107,367,753.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	107,367,753.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	107,367,753.00

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Бөмбөгөр сумын Засаг даргын Тамгын газар нь орчин үеийн тэргүүний дэвшилтэт технологи нэвтэрсэн өндөр мэргэжилтэй, чадварлаг боловсон хүчний чадварт түшиглэн төрийн үйлчилгээг үзүүлэх зорилгын хүрээнд тайлант онд дараахь зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Сумын нийгэм эдийн засгийг хөгжүүлэх, төлөвлөгөөт зорилтуудыг биелүүлэх, мал аж ахуйн материаллаг баазыг бэхжүүлэх, ард иргэдийн амьдрал ахуйг дээшлүүлэх ажлыг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах
- Төрийн албан хаагчдын ажлын ачааллыг жигдрүүлэн ажиллахад ажлынхаа голыг чиглүүлж, ажилтан албан хаагчдын ажил үүргийг тодорхойлж, хөдөлмөрийн гэрээ байгуулан, хөдөлмөрийн хамт олны ажлын амжилт, ололтыг бататгах, дутагдлыг арилгах зорилт тавин ажиллаж байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бөмбөгөр сумын ЗДТГ нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Бөмбөгөр сумын ЗДТГ нь аймгийн Санхүү, Төрийн сангийн хэлтсээс баталсан “Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын жишиг баримт бичиг”-ийг дагаж мөрдөж байгаа бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Бөмбөгөр сумын ЗДТГ нь 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Бөмбөгөр сумын ЗДТГ нь 2023 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 1,388,822.2 мянган төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 119,325.3 мянган төгрөгөөр буюу 9.4 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	14.8	57,732.0	57,717.2
Бараа материал	60,367.5	110,008.6	49,641.0
Үндсэн хөрөнгө	2,109,774.8	2,157,620.6	47,845.8
Хуримтлагдсан элэгдэл	(900,660.2)	(936,538.9)	(35,878.7)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,269,496.9</b>	<b>1,388,822.2</b>	<b>119,325.3</b>
Өр төлбөр	557.4	6.5	(550.8)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,268,939.5	1,388,815.7	119,876.1
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,269,496.9</b>	<b>1,388,822.2</b>	<b>119,325.3</b>

Эх сурвалж: Байгууллагын 2023 оны санхүүгийн тайлан

Авлага дансны үлдэгдэл 57,732.0 мянган төгрөг болж 57,717.2 мянган төгрөгөөр өссөн нь 57,600.0 мянган төгрөгийн өртөгтэй 2 моторыг Баянхонгор аймгийн Прокурорын 2023.05.30-ны өдрийн 39 дугаар тогтоолыг үндэслэн Орон нутгийн өмчийн газраас өгсөн чиглэлийн дагуу дансанд бүртгэлтэй байсан моторыг үндсэн хөрөнгөөс хасаж авлагаар бүртгэсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 110,008.6 мянган төгрөг болж 49,641.0 мянган төгрөг өссөн нь төсвийн хөрөнгөөр 170,740.4 мянга, үнэ төлбөргүй хүлээн

**Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**  
авсан 64,935.2 мянга нийт 235,675.6 мянган төгрөгийн орлого авч 186,034.6 мянган төгрөгийн материалыг зарцуулсантай холбоотой байна.

Тайлант онд улсын онцгой комиссоос 18,910.4 мянган төгрөгийн өвс, тэжээл, сумын Орон нутгийн хөгжлийн сангаас 9,996.0 мянга, аймгийн Хөдөө аж ахуйн газраас Сэлэнгэ үүлдрийн үхэр, бух, хуц 29,528.8 мянга, сумын Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээс улаан ухна ишиг 6.5 мянга нийт 64,935.2 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй шилжүүлэн авсан байна

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,157,620.6 мянган төгрөг болж 47,845.8 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 53,012.5 мянга, аймгийн орон нутгийн төсвөөс хийсэн хөрөнгө оруулалтаар 3,500.0 мянга, сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 48,933.2 мянга нийт 105,445.7 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй шилжүүлэн авч тооллогоор дутагдсан 57,600.0 мянган төгрөгийн эрчим хүчний моторыг данснаас хассантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 6.5 мянган төгрөг болж 550.8 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны ажиллагсадтай холбогдсон өглөгтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,388,815.7 мянган төгрөг болж 119,876.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 119,876.1 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 656,182.4 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 1,000.0 мянган төгрөгөөр тус тус санхүүжүүлэхээр, нийт зарлагыг 657,182.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 50,463.4 мянган төгрөгөөр бууруулж 606,719.0 мянган төгрөгөөр анх батлагдсан ба тодотголоор 750,367.4 мянган төгрөг болгож 143,648.4 мянган төгрөгөөр өсгөн баталсан байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 750,367.4 мянган төгрөг батлагдсанаас 717,036.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 717,036.2 мянган төгрөг буюу 95.6 хувьтай байгаа нь үндсэн үйл үйл ажиллагааны зардлаас 3,591.7 мянга, баг хорооны үйл хорооны үйл ажиллагааны зардлаас 817.1 мянга, байгаль орчныг хамгаалах нөхөн

Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

сэргээх арга хэмжээний зардлаас 28,171.6 мянган төгрөгийг тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80101 үндсэн үйл ажиллагаа зардал	487,437.6	483,845.9	3,591.7	99.3
2	80106 Баг хорооны үйл ажиллагааны зардал	93,874.8	93,057.7	817.1	99.1
3	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж	5,200.0	4,590.0	610.0	88.3
4	81102 Орон нутгийн нөөц хөрөнгө	30,000.0	29,881.1	118.9	99.6
5	81701 Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардал	116,000.0	87,828.4	28,171.6	75.7
6	82212 Хур хог хаягдал, орчны бохирдол	17,855.0	17,833.1	21.9	99.9
	Нийт дүн	750,367.4	717,036.2	33,331.2	95.6

Эх сурвалж: Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Үндсэн үйл ажиллагааны зардлаас 2,591.7 мянга буюу 0.5 хувь, баг хорооны үйл ажиллагааны зардлаас 817.1 мянга буюу 0.8 хувь, ажил олгогчоос олгох тэтгэмж урамшууллын зардлаас 610.0 мянга буюу 11.7 хувь, орон нутгийн нөөц хөрөнгө 118.9 мянга буюу 0.4 хувь, байгаль орчны хамгаалах нөхөн сэргээх зардал 28,171.6 мянга буюу 24.3 хувь, хур хаягдал, орчны бохирдлын зардлаас 21.9 мянга буюу 0.1 хувийг тус тус буцаан төвлөрүүлсэн байна.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар дараах орлого төвлөрсөн байна.

Хүснэгт 3. Нэмэлт санхүүжилтийн орлого

/мян.төг/

д/д	Орлогын төрөл	Авсан санхүүжилт
1	Түрээсийн төлбөр	2,400.0
2	Статистикийн хэлтэс хагас жилийн мал тооллогын зардал	1,214.9
3	Усны орлого	1,498.4
4	Хөдөө аж ахуйн газар-хортон шавж устгалын төлбөр	4,000.0
5	Хамтдаа шийдье аян зохион байгуулах-Малчдын замын шатахууны зардал	309.7
6	Сангийн сайдын тушаал '151 2023.07.20 Хөрөнгө гаргах тухай тушаал	90,000.0
7	Тендерийн хураамж	420.0
8	Нөхөн сэргээлтийн зардал	7,524.7
	Нийт орлогын дүн	107,367.7

Эх сурвалж: Нэмэлт санхүүжилтийн дансны хуулга

Дээрх орлогыг зориулалтын дагуу зарцуулж 99,463.2 мянган төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлсэн байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Бөмбөгөр сумын ЗДТГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Бунчинсүрэн гүйцэтгэж, ахлах аудитор М.Алтантуяа, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Бөмбөгөр сумын ЗДТГ нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 12 дүгээр сарын 19-ны өдрийн 86 тоот албан бичгээр ирүүлсэн.

2023 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Ц.Мөнхжаргал, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч С.Баттулга нар зурж хөрөнгийг захиран зарцуулжээ.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн нийт зардлыг сонгож, материаллаг байдлын түвшин 1.5 хувиар тооцож материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 545,029.1 мянган төгрөгөөс тооцоход 8,175.4 мянган төгрөг байгаа ба гүйцэтгэлийн материаллаг байдлыг 70 хувиар буюу 5,722.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Бөмбөгөр сумын ЗДТГ нь Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой 3,461.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоолоо.

1. Сумын ЗДТГ-ын 2023.06.22 -ны өдрийн А/18 дугаар тушаалаар Баянхонгор аймгийн Хангайн сумдын ИТХ, ЗДТГ-ын туршлага солилцох чуулга уулзалтын тэмцээний зардалд 880.0 мянган төгрөгийг шилжүүлсэн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-т "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Хууль зөрчин зарцуулсан уралдаан тэмцээний зардлын 880.0 мянган төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Сумын ЗДТГ-ын 2023.11.28 -ны өдрийн А/36 дугаар тушаалаар сумдын ИТХ, ЗДТГ-ын туршлага солилцох чуулга уулзалтын хоолны зардалд 2,581.0 мянган төгрөгийг шилжүүлсэн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-т "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Хууль зөрчин зарцуулсан туршлага солилцох чуулга уулзалтын хоолны зардалд 2,581.0 мянган төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь 2023 онд 159 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 129 мэдээллийг хугацаанд нь байршуулсан, 25 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 5 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

Тайлант онд шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 689,304.6 мянган төгрөгийн 30 гүйлгээ мэдээлэхээс 584,457.7 мянган төгрөгийн 23 гүйлгээ мэдээлээгүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 238,071.9 мянган төгрөгийн 13 гүйлгээ мэдээлэхээс 56,465.0 мянган төгрөгийн 4 гүйлгээ мэдээлээгүй, бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрт 149,422.3 мянган төгрөгийн 65 мэдээллийг

байршуулахаас Засаг дарга нөөц хөрөнгө зарцуулах 1 захирамжийн 1,416.7 мянга, Байгаль орчин нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 32,246.8 мянган төгрөгийн 5 захирамжийг тус тус мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5 дахь "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8 дахь "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т заасан мэдээлэл, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлага, бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрт хөрөнгө зарцуулах шийдвэрийг хугацаанд үнэн зөв мэдээлж байх албан шаардлагыг хүргүүлэв.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсар үеийн аудитыг 2023 оны 10 сарын 20-ны өдрөөс 10 сарын 22 өдрүүдэд хийсэн бөгөөд цалин, НДШ-ийн нягтлан бодох бүртгэлийн бичилтийг буруу хийсэнтэй холбоотой залруулах бичилт хийх зөвлөмжийг хүргүүлж санхүүгийн тайланд залруулсан.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нийт 353,073.1 мянган төгрөгийн 9 зөрчил илэрснээс 1,360.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 77,600.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлага, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх талаар 274,113.1 мянган төгрөгийн дүн бүхий 4 зөвлөмжийг өгсөн ба Бөмбөгөр сумын ЗДТГ-ын 2023.05.30-ны өдрийн 45 тоот албан бичгээр хэрэгжилтийг тооцсон байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	1,360.0	1	1,360.0	100
Албан шаардлага	3	77,600.0	3	77600.0	95
Зөвлөмж	4	274,113.1	4	274,113.1	100
<b>Нийт дүн</b>	<b>8</b>	<b>353,073.1</b>	<b>8</b>	<b>353,073.1</b>	<b>97.5</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 43,328.1 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс, 3,461.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 9,867.1 мянган төгрөгийн 2 зөрчлийг арилгах албан шаардлага, 30,000.0 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмжийг хүргүүлэвб

#### 5.1 Төлбөрийн акт

1. Сумын ЗДТГ-ын 2023.06.22 -ны өдрийн А/18 дугаар тушаалаар Баянхонгор аймгийн Хангайн сумдын ИТХ, ЗДТГ-ын туршлага солилцох чуулга уулзалтын тэмцээний зардалд 880.0 мянган төгрөгийг шилжүүлсэн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-т "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Хууль зөрчин зарцуулсан уралдаан тэмцээний зардлын 880.0 мянган төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Сумын ЗДТГ-ын 2023.11.28 -ны өдрийн А/36 дугаар тушаалаар сумдын ИТХ, ЗДТГ-ын туршлага солилцох чуулга уулзалтын хоолны зардалд 2,581.0 мянган төгрөгийг шилжүүлсэн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-т "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Хууль зөрчин зарцуулсан туршлага солилцох чуулга уулзалтын хоолны зардалд 2,581.0 мянган төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

#### 5.2 Албан шаардлага

1. Тайлант онд 9,867.1 мянган төгрөгийн зарлага гаргасан ба тухайн авто тээврийн хэрэгслийн ашиглалт, сэлбэг эд ангийг солихдоо байгууллагын өмч хамгаалах зөвлөл нь шийдвэр гаргаагүй байна

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 04 сарын 03-ны өдрийн 86 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам"-ын 3.13-т " Өмч хамгаалах зөвлөл нь хуулийн этгээдийн тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалт, сэлбэг эд ангийг солих, барилга байгууламжийн их засвар хийх тохиолдолд батлагдсан норм

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан  
стандартыг мөрдүүлэх, барилгын болон техникийн хувийн хэрэгт нь баяжилт хийлгэх зэргээр хяналт тавьж ажиллана" гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Байгууллагын өмч хамгаалах зөвлөл нь тээврийн хэрэгслийн сэлбэг, эд ангийг солихдоо батлагдсан норм стандартын дагуу тухай бүр дүгнэлт гаргаж зөрчлийг арилгах албан шаардлагыг хүргүүлэв.

2. Тухайн байгууллагын санхүүгийн тайланд 5233 м2 газар бүртгэлтэй байгаа бөгөөд Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраас ирүүлсэн судалгаанд 14730 м2 газар бүртгэлтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл, 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Газрын бүртгэлтэй холбоотой зөрчлийг арилгах албан шаардлагыг хүргүүлэв.

3. Тайлант онд шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 689.304.6 мянган төгрөгийн 30 гүйлгээ мэдээлэхээс 584,457.7 мянган төгрөгийн 23 гүйлгээ мэдээлээгүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 238,071.9 мянган төгрөгийн 13 гүйлгээ мэдээлэхээс 56,465.0 мянган төгрөгийн 4 гүйлгээ мэдээлээгүй, бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрт Засаг дарга нөөц хөрөнгө зарцуулах 1 захирамжийн 1,416.7 мянга, Байгаль орчин нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 32,246.8 мянган төгрөгийн 5 захирамжийг тус тус мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5 дахь "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8 дахь "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг бүрэн байршуулж, зөрчлийг арилгах, цаашид зөрчлийг дахин давтан гаргахгүй байх орхигдуулсан мэдээллийг байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлэх албан шаардлагыг хүргүүлэв.

### **5.3 Зөвлөмж**

1. Байгал хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас ан, агнуурын бүс нутгийн 2 газарт булаг, шандыг хашиж хамгаалах, сэргээн засварлах ажлыг гүйцэтгүүлэхээр Баялаг алтан ганьдирс ХХК-тай 30,000.0 мянган төгрөгөөр худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй шууд гэрээ байгуулсан байна

Энэ нь Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т "Засгийн газар нь барааны, ажлын, үйлчилгээний гэсэн ангилал тус бүрээр дараах босго үнийг тогтооно" 8.1.1-

**Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

т "Харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар", Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолын хавсралтад заасан босго үнийг баримтлаагүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авахдаа холбогдох хууль тогтоомжийг дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж байх цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй зөвлөмжийг хүргүүлэв.

2. Тухайн байгууллага нь 2023 сарын 10 сарын 10-д нэгдсэн халаалтад холбогдож Дулааны эрчим хүчээр хангах аж ахуйн гэрээг "Буянт сэрвэн" ХХК-тай байгуулсан байна. Уг гэрээнд халаах талбай, эзлэхүүний хэмжээг бичээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.4-т "Үнэн зөв байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Халаах талбайн хэмжээг мэргэжлийн байгууллагаар хэмжүүлэх зөвлөмжийг хүргүүлж байна.

Дээрх акт, албан шаардлагын биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

(мянган төгрөг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд 9,867.1 мянган төгрөгийн зарлага гаргасан ба тухайн авто тээврийн хэрэгслийн ашиглалт, сэлбэг эд ангийг солихдоо байгууллагын өмч хамгаалах зөвлөл нь шийдвэр гаргаагүй байна.	1	9,867.1	-	-	1	9,867.1	-	-
Байгал хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас ан, агнуурын бүс нутгийн 2 газарт булаг, шандыг хашиж хамгаалах, сэргээн засварлах 30,000.0 мянган төгрөгийн ажлыг худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй шууд гэрээ байгуулсан байна.	1	30,000.0	-	-	-	-	1	30,000.0
Баянхонгор аймгийн Хангайн сумдын ИТХ, ЗДТГ-ын туршлага солилцох чуулга уулзалтын тэмцээний зардалд 880.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.	1	880.0	1	880.0				
Сумдын ИТХ, ЗДТГ-ын туршлага солилцох чуулга уулзалтын хоолны зардалд 2,581.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.	1	2,581.0	1	2,581.0				
Тухайн байгууллага нь 2023 сарын 10 сарын 10-д нэгдсэн халаалтад холбогдож Дулааны эрчим хүчээр хангах аж ахуйн гэрээг "Буянт сэрвэн" ХХК-тай байгуулсан байна. Уг гэрээнд халаах талбай, эзлэхүүний хэмжээг бичээгүй байна.	1	0					1	0
Тухайн байгууллагын санхүүгийн тайланд 5233 м2 газар бүртгэлтэй байгаа бөгөөд Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраас ирүүлсэн судалгаанд 14730 м2 газар бүртгэлтэй байна.	1	0			1	0		
<b>Дүн</b>	<b>6</b>	<b>43,328.1</b>	<b>2</b>	<b>3,461.0</b>	<b>1</b>	<b>9,867.1</b>	<b>2</b>	<b>30,000.0</b>

**Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

(мянган төгрөг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуультай холбоотой зөрчил</b>								
Тайлант онд шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 584,457.7 мянган төгрөгийн 23 гүйлгээ мэдээлээгүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 56,465.0 мянган төгрөгийн 4 гүйлгээ мэдээлээгүй, бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрт Засаг дарга нөөц хөрөнгө зарцуулах 1 захирамжийн 1,416.7 мянга, Байгаль орчин нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 32,246.8 мянган төгрөгийн 5 захирамжийг тус тус мэдээлээгүй байна.	1	674,586.2			1	674,586.2	-	-
<b>Дүн</b>	1	674,586.2			1	674,586.2	-	-

-----oOo-----



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2024 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 31/АОС70240/АМА-2024/153/АА-СТА-ТМЗ  
Номгон

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Бөмбөгөр сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 11 дүгээр сарын 28 -ны өдрийн А/36 дугаар тушаалаар сумдын ИТХ, ЗДТГ-ын туршлага солилцох чуулга уулзалтын хоолны зардалд 2,581,000 (Хоёр сая таван зуун наян нэгэн мянган) төгрөгийг шилжүүлсэн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-т "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.3 дахь "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон", 4.2.3.8 дахь "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2.1.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Хууль зөрчин зарцуулсан уралдаан тэмцээний зардлын 2,581,000 (Хоёр сая таван зуун наян нэгэн мянган) төгрөгийг төсөв захирагчаар төлүүлж, Төрийн сан дахь 100030000947 тоот төгрөгийн дансанд төвлөрүүлэх.

5050097

2. Аудитаар тогтоосон төлбөрийн актыг бүрэн барагдуулж, нотлох баримтыг 2024 оны 03 дугаар сарын 25-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт<sup>1</sup> ирүүлэхийг Бөмбөгөр сумын Засаг даргын Тамгын газрын дарга Ц.Мөнхжаргал, нягтлан бодогч С.Баттулга нарт даалгав<sup>2,3</sup>.

**ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН<sup>4</sup>:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТОР

Б.МӨНХБАТ

Н.БҮНЧИНСҮРЭН



<sup>1</sup> Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

<sup>2</sup> Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана"

<sup>3</sup> Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

<sup>4</sup> Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 54/А0570240/ТНА-2024/153/МА-СТА-ТМЗ  
Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Бөмбөгөр сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 9,867,100 (Есөн сая найман зуун жаран долоон мянга нэг зуун) төгрөгийн сэлбэг хэрэгслийн зарлага гаргасан ба тухайн авто тээврийн хэрэгслийн ашиглалт, сэлбэг эд ангийг солихдоо байгууллагын өмч хамгаалах зөвлөл нь шийдвэр гаргаагүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 04 сарын 03-ны өдрийн 86 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам"-ын 3.13-т "Өмч хамгаалах зөвлөл нь хуулийн этгээдийн тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалт, сэлбэг эд ангийг солих, барилга байгууламжийн их засвар хийх тохиолдолд батлагдсан норм стандартыг мөрдүүлэх, барилгын болон техникийн хувийн хэрэгт нь баяжилт хийлгэх зэргээр хяналт тавьж ажиллана" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх "хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Байгууллагын өмч хамгаалах зөвлөлөөр сольсон тээврийн хэрэгслийн сэлбэг, эд ангийн дүгнэлт гаргаж нотлох баримтыг FAS системд оруулж нотлох

5040105

баримтыг 2024 оны 05 дүгээр сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Бөмбөгөр сумын Засаг даргын Тамгын газрын дарга Ц.Мөнхжаргал, нягтлан бодогч С.Баттулга нарт даалгав<sup>1,2</sup>.

**АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН<sup>3</sup>:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Б.МӨНХБАТ

АУДИТОР:

*Н.Бунчинсүрэн*

Н.БҮНЧИНСҮРЭН

A large, stylized handwritten signature in black ink is written over a red rectangular official stamp. The stamp contains Mongolian text and numbers, including '647710011' and '50477100123'. The signature is written across the stamp and extends to the right.

<sup>1</sup> Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

<sup>2</sup> Монгол улсын ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

<sup>3</sup> Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2024 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 30/А0570240/АМА-2024/153/НА-СТА-ТМЗ  
Номгон

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Бөмбөгөр сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 06 дугаар сарын 22 -ны өдрийн А/18 дугаар тушаалаар Баянхонгор аймгийн Хангайн сумдын ИТХ, ЗДТГ-ын туршлага солилцох чуулга уулзалтын тэмцээний зардалд 880,000 (Найман зуун наян мянган) төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-т "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.3 дахь "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон", 4.2.3.8 дахь "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2.1.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

5050094

1. Хууль зөрчин зарцуулсан уралдаан тэмцээний зардлын 880,000 (Найман зуун наян мянган) төгрөгийг төсөв захирагчаар төлүүлж, Төрийн сан дахь 100030000947 тоот төгрөгийн дансанд төвлөрүүлэх.
2. Аудитаар тогтоосон төлбөрийн актыг бүрэн барагдуулж, нотлох баримтыг 2024 оны 03 дугаар сарын 25-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт<sup>1</sup> ирүүлэхийг Бөмбөгөр сумын Засаг даргын Тамгын газрын дарга Ц.Мөнхжаргал, нягтлан бодогч С.Баттулга нарт даалгав<sup>2,3</sup>.

#### ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН<sup>4</sup>:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТОР

Б.МӨНХБАТ

Н.БҮНЧИНСҮРЭН

<sup>1</sup> Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

<sup>2</sup> Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана"

<sup>3</sup> Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

<sup>4</sup> Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 08 сарын 23 өдөр

Дугаар 55/А0570240/БАА-2024/153/НА Номгон

- ГА-ТМЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Бөмбөгөр сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 689,304,600 (Зургаан зуун наян есөн сая гурван зуун дөрвөн мянга зургаан зуун) төгрөгийн 30 гүйлгээ мэдээлэхээс 584,457,700 (Таван зуун наян дөрвөн сая дөрвөн зуун тавин долоон мянга долоон зуун) төгрөгийн 23 гүйлгээ мэдээлээгүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 238,071,900 (Хоёр зуун гучин найман сая далан нэгэн мянга есөн зуун) төгрөгийн 13 гүйлгээ мэдээлэхээс 56,465,000 (Тавин зургаан сая дөрвөн зуун жаран таван мянган) төгрөгийн 4 гүйлгээ мэдээлээгүй, бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрт 149,422,300 (Нэг зуун дөчин есөн сая дөрвөн зуун хорин хоёр мянга гурван зуун) төгрөгийн 65 мэдээллийг байршуулахаас Засаг дарга нөөц хөрөнгө зарцуулах 1 захирамжийн 1,416,700 (Нэг сая дөрвөн зуун арван зургаан мянга долоон зуун) төгрөг, Байгаль орчин нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 32,246,800 (Гучин хоёр сая хоёр зуун дөчин зургаан мянга найман зуун) төгрөгийн 5 захирамжийг тус тус мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5 дахь "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8 дахь "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ,

3040186

төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх "хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг бүрэн байршуулж, зөрчлийг арилгаж нотлох баримтыг FAS системд оруулж, нотлох баримтыг 2024 оны 05 дүгээр сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Бөмбөгөр сумын Засаг даргын Тамгын газрын дарга Ц.Мөнхжаргал, нягтлан бодогч С.Баттулга нарт даалгав<sup>1,2</sup>.

### АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН<sup>3</sup>.

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Б.МӨНХБАТ

АУДИТОР:

Н.БҮНЧИНСҮРЭН

<sup>1</sup> Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

<sup>2</sup> Монгол улсын ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

<sup>3</sup> Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно